

2019 оны II улирал

НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2019
оны II улирлын санхүүгийн тайлангийн
нэгтгэлийн танилцуулга

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага
тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

Агуулга

1. Салбарын өнөөгийн байдал	1
1.1 Ерөнхий төлөв байдал	1
1.2 Статистик үзүүлэлтүүд	2
2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа	6
2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт	6
2.2 Зээл.....	8
2.2.1 Зээлийн зориулалт	8
2.2.2 Зээлийн багцын чанар	8
2.2.3 Зээлдэгчид	9
3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	11
3.1 Өр төлбөр.....	11
3.2 Эздийн өмч.....	13
4. Орлого, үр дүнгийн тайлан.....	15
4.1 Орлого.....	15
4.2 Зарлага	16
4.3 Ашигт ажиллагаа	16
5. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	17
5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	17
5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	17
5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	17
6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	12
6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд	12
6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд.....	13
6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд	14
ДҮГНЭЛТ.....	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл.....	1
Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо.....	1
Хүснэгт 3 Харилцагчид.....	2
Хүснэгт 4 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/.....	3
Хүснэгт 5 ББСБ-уудын тархалт /хот/.....	3
Хүснэгт 6 ББСБ-уудын тархалт /ХОН/.....	3
Хүснэгт 7 Активын бүтэц /сая төгрөгөөр/.....	6
Хүснэгт 8 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/.....	6
Хүснэгт 9 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	8
Хүснэгт 10 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/.....	8
Хүснэгт 11 Ерөнхий статистик /харилцагчид/.....	9
Хүснэгт 12 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/.....	11
Хүснэгт 13 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/.....	14
Хүснэгт 14 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая төгрөгөөр/.....	16
Хүснэгт 15 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	16
Хүснэгт 16 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ.....	17
Хүснэгт 17 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ.....	17
Хүснэгт 18 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ.....	17
Хүснэгт 19 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	11
Хүснэгт 20 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл.....	12
Хүснэгт 21 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц.....	12
Хүснэгт 22 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц.....	13
Хүснэгт 23 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл.....	13
Хүснэгт 24 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/.....	14
Хүснэгт 25 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив /мянган төгрөгөөр/.....	14
Хүснэгт 26 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив.....	14
Хүснэгт 27 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /мянган төгрөгөөр/.....	15
Хүснэгт 28 Орлогын бүтэц.....	15

Зургийн жагсаалт

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо.....	1
Зураг 2 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо.....	2
Зураг 3 Санхүүгийн програм ашиглалт.....	3
Зураг 4 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /тэрбум төгрөгөөр/.....	6
Зураг 5 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/.....	7
Зураг 6 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	7
Зураг 7 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	7
Зураг 8 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/.....	8
Зураг 9 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/.....	8
Зураг 10 Зээлийн чанар.....	9
Зураг 11 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа.....	9
Зураг 12 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	9
Зураг 13 Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	11
Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/.....	13
Зураг 15 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	13
Зураг 16 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	15


Зураг 17 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/	15
Зураг 18 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/	15
Зураг 19 Үндсэн бус үйл ажиллагааны орлого /сая төгрөгөөр/	16
Зураг 20 Зохистой харьцаа	17
Зураг 21 ББСБ-уудын тархалт	12
Зураг 22 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	13
Зураг 23 Зарлагын бүтэц /ХОН-ын ББСБ-ууд/	13
Зураг 24 Хүүгийн бус зардлын бүтэц	15

1. Салбарын өнөөгийн байдал

1.1 Ерөнхий төлөв байдал

2019 оны хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 538 ББСБ байна. Энэ нь өмнөх оны мөн үе болон оны эхнээс 1 ББСБ буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлт юм.

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



2019 оны хагас жилийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ байгаа бол хөдөө орон нутагт 75 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

	2015-II	2016-II	2017-II	2018-II	2019-II
Шинээр олгосон	53	53	20	10	5
Хүчингүй	8	4	5	5	6
Түдгэлзүүлсэн	4	0	17	15	6
Сэргээсэн	3	1	0	2	6
Нийт ББСБ	423	499	533	539	538

2019 оны эхний хагас жилд 5 ББСБ-д шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 6 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 6 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаанд түдгэлзүүлж, 6 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээсэн байна.

Үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2019 оны II улирлын байдлаар 538 ББСБ 9 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 792 үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 91.5% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 351 ББСБ буюу 65.1% нь дагнан эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 28.8% нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 44 ББСБ буюу 8.2% дагнан эрхэлж байна.

Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өсөлт	
		2018-II	2019-II	тоо	хувь
	Нийт ББСБ	539	538	-1	-0.2%
1	Зээл	490	492	2	0.4%
	<i>Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	357	351	-6	-1.7%
2	Факторингийн үйлчилгээ	20	24	4	20.0%
3	Төлбөрийн баталгаа гаргах	18	19	1	5.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	3	3	0	0.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	23	27	4	17.4%
6	Гадаад валютын арилжаа	152	154	2	1.3%
	<i>Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	53	44	-9	-17.0%
7	Итгэлцлийн үйлчилгээ	29	31	2	6.9%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	9	10	1	11.1%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	31	32	1	3.2%


ББСБ-ууд тооны өсөлтөөс илүүтэйгээр үйл ажиллагаагаа өргөжүүлж байгаа нь эрхэлж буй үйл ажиллагааны өсөлтөөс харагдаж байна. Өмнөх оны мөн үед 539 ББСБ 775 үйл ажиллагаа эрхэлж байсан бол 2019 оны хагас жилийн байдлаар 538 ББСБ 792 үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн зээлийн болон гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын тоо харгалзан 1.7 болон 17.0 хувиар буурсан байна.

1.2 Статистик үзүүлэлтүүд

2019 оны II улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 538 ББСБ-аас 96.3% буюу 518 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 20 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан байна.

2019 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 7618 хувь нийлүүлэгчдийн 538 ББСБ, 235 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 2921 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 2,348,014 харилцагчдад хүрч үйлчилж байна.

Зураг 2 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо



Харилцагчид

Хүснэгт 3 Харилцагчид

	ББСБ тоо	Хувь	Харилцагчдын тоо	Хувь
Финтек	7	1.3%	2,148,456	91.5%
Уламжлалт	531	98.7%	79,145	3.4%
100-аас доош	340	63.2%	12,509	0.5%
100-1000	151	28.1%	42,005	1.8%
1001-10,000	10	1.9%	123,709	5.3%
10,000-1,000,000	6	1.1%	738,881	31.5%
1,000,000-аас дээш	1	0.2%	1,430,910	60.9%
НИЙТ	538	100.0%	2,348,014	100.0%

Нийт харилцагчдын 49.8% нь эмэгтэй, 50.1% нь эрэгтэй, 0.1% нь хуулийн этгээд байна. ББСБ-уудын харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өссөн байна.

Нийт харилцагчдын 91.5 хувийг финтек ашиглан үйлчилгээ үзүүлж буй 7 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид

2019 оны II улирлын байдлаар 538 ББСБ-ын 7618 хувьцаа эзэмшигч байна. ББСБ-ууд хувьцааны тодорхой хэсгийг нийтэд санал болгож хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болж байгаатай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өсжээ. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийг оролцуулалгүйгээр 1038 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байна.

Нийт 538 ББСБ-ын 297 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 232 ББСБ нь 2-9, 5 ББСБ нь 10-аас дээш хувьцаа эзэмшигчтэй байна. Хувьцаат компанийг оролцуулалгүйгээр хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй ББСБ бол 2007 онд байгуулагдсан Хөвсгөл аймагт үйл ажиллагаа эрхэлдэг 36 хувьцаа эзэмшигчтэй “Хөгжил бадрах ББСБ” ХХК байна.

Ажиллагсад

538 ББСБ-д 2921 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.3 хувь буюу 319 ажилтнаар нэмэгдсэн дүн юм. Нийт ажилчдын 57.8 % буюу 1688 нь эмэгтэй 1233 нь эрэгтэй ажилчид байгаа нь хүйсийн тэнцвэртэй байдлыг харуулж байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-уудын нийт активын хэмжээ банкны салбарын 4.4 хувьтай, нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ 6.2 хувьтай тэнцэж байна. Банкны салбартай харьцуулахад өөрийн хөрөнгө 37.2 хувьтай тэнцэж байгаа бол өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгөөрөө эрсдэлээ үүрч үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

банкны салбартай харьцуулахад 35.3 тэрбум төгрөгөөр илүү байна.


Хүснэгт 4 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2018-II	2018-IV	2019-II
Нийт хөрөнгө	1,143.7	1284.9	1,533.1
Банкны салбартай харьцуулахад хувиар	3.8%	3.9%	4.4%
Нийт өөрийн хөрөнгө	888.5	977.4	1,155.2
Банкны салбартай харьцуулахад хувиар	27.9%	30.0%	37.2%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	707.8	740.6	892.2
Банкны салбартай харьцуулахад хувиар	90.4%	83.8%	104.1%
Нийт зээл	768.3	869.2	1,024.5
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.0%	5.1%	6.2%
Нийт орлого	118.4	259.5	158.3
Нийт зарлага	71.9	158.4	94.0
Цэвэр ашиг	46.5	101.1	64.3

Програм ашиглалт

2019 оны II улирлын байдлаар 538 ББСБ-ын 351 нь буюу 65.2% нь үйл ажиллагаандаа санхүүгийн програм ашиглаж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 461 ББСБ-ын 292 нь буюу 63%, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 76 ББСБ-ын 45% нь санхүүгийн програмтай байна.

Зураг 3 Санхүүгийн програм ашиглалт



ББСБ-уудын дийлэнх нь “Ай Би Ай” ХХК-ийн Спинел болон Даймонд програм, “Грейпсити” ХХК-ийн Ачидбанк болон MARS програмуудыг ашиглаж байна.

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 86.1% буюу 463 ББСБ, салбаруудын 70.0% буюу 164 салбар байршиж байна.

Хүснэгт 5 ББСБ-уудын тархалт /хот/

Дүүрэг	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Сүхбаатар	160	23	183	29.2%
Чингэлтэй	147	26	173	27.6%
Баянгол	67	29	96	15.3%
Баянзүрх	52	42	94	15.0%
Хан-Уул	29	17	46	7.3%
Сонгинохайрхан	7	21	28	4.5%
Багануур	1	4	5	0.8%
Налайх	0	2	2	0.3%
Багахангай	0	0	0	0.0%
НИЙТ /хот/	463	164	627	100.0%

Орон нутагт нийт ББСБ-ын 13.9% буюу 75 ББСБ, салбаруудын 30.0% буюу 71 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 6 ББСБ-уудын тархалт /ХОН/

Аймаг	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Архангай	2	1	3	2.1%
Баян-Өлгий	3	1	4	2.7%
Баянхонгор	4	4	8	5.5%
Булган	2	-	2	1.4%
Говь-Алтай	1	-	1	0.7%
Говьсүмбэр	2	1	3	2.1%
Дархан-Уул	7	11	18	12.3%
Дорноговь	3	3	6	4.1%
Дорнод	5	6	11	7.5%
Дундговь	1	1	2	1.4%
Завхан	2	1	3	2.1%
Орхон	7	10	17	11.6%
Өвөрхангай	6	4	10	6.8%
Өмнөговь	1	8	9	6.2%
Сүхбаатар	3	2	5	3.4%
Сэлэнгэ	6	4	10	6.8%
Төв	11	2	13	8.9%
Увс	2	2	4	2.7%
Ховд	1	3	4	2.7%
Хөвсгөл	3	5	8	5.5%
Хэнтий	3	2	5	3.4%
НИЙТ /ХОН/	75	71	146	100.0%

Нийт 69 ББСБ-ын 235 салбар бүртгэлтэй байгаа ба үүний 36.2 хувийг 5 ББСБ-ын 85

салбар бүрдүүлж байгаа бол 6-9 салбартай 7 БСББ-ын 53 салбар, 2-5 салбартай 24 ББСБ-ын 64 салбар, 1 салбартай 33 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Нийт 6 ББСБ-ын 7 төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаа ба Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Баянгол дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Баянзүрх дүүрэг, Булган аймгийн Булган сум болон Америкийн Нэгдсэн улсын Вашингтон хотод тус тус байршиж байна.

2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа

2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт

2019 оны II улиралд ББСБ-уудын актив 1.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 34.0% буюу 389.4 тэрбум

төгрөгөөр, оны эхнээс 19.3% буюу 248.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 7 Активын бүтэц /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2018-II дүн	2018-IV дүн	2019-II дүн	Өөрчлөлт			
				оны эхэн		өмнөх оны мөн үе	
				дүн	хувь	дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,101,049.7	1,234,705.7	1,477,935.1	243,229.5	19.7%	376,885.5	34.2%
Мөнгөн хөрөнгө	277,115.1	315,113.9	318,846.7	3,732.7	1.2%	41,731.6	15.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	2,126.0	1,837.5	2,427.3	589.8	32.1%	301.3	14.2%
Нийт зээл (Зээлийн эрсдэлийн сан)	768,346.0	869,222.4	1,096,712.7	227,490.3	26.2%	328,366.7	42.7%
Зээл (цэврээр)	57,788.7	64,476.9	72,203.1	7,726.2	12.0%	14,414.4	24.9%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	710,557.3	804,745.6	1,024,509.6	219,764.0	27.3%	313,952.3	44.2%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	232.7	7,292.9	4,629.3	-2,663.6	-36.5%	4,396.6	19.9 дахин
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	9,821.4	10,223.0	10,295.9	72.9	0.7%	474.6	4.8%
Бусад хөрөнгө	101,197.2	95,492.8	117,226.4	21,733.5	22.8%	16,029.1	15.8%
Эргэлтийн бус хөрөнгө	42,646.7	50,191.7	55,179.4	4,987.7	9.9%	12,532.7	29.4%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	42,646.7	50,191.7	55,179.4	4,987.7	9.9%	12,532.7	29.4%
Нийт хөрөнгийн дүн	1,143,696.4	1,284,897.4	1,533,114.6	248,217.2	19.3%	389,418.2	34.0%

Салбарын нийт активын 96.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.6 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгө оны эхнээс 19.7% буюу 243.2 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 34.2% буюу 376.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 48 ББСБ нийт активын 50.1 хувийг, 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 379 ББСБ нийт активын 47.9 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 111 ББСБ нийт активын 2.0 хувийг эзэлж байна.


Активын өсөлтийн 80.6 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/

Интервал	ББСБ тоо	Дүн	Эзлэх хувь
1 тэрбумаас доош	111	30.9	2.0%
1-4.9 тэрбум хүртэл	379	734.0	47.9%
5 тэрбум ба түүнээс дээш	48	768.2	50.1%
НИЙТ	538	1,533.1	100%

- Мөнгөн хөрөнгө

Зураг 4 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /тэрбум төгрөгөөр/



Нийт активын 20.8% буюу 318.8 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Үүнээс 160.8 тэрбум төгрөг буюу мөнгөн хөрөнгийн 50.4% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 94.9 тэрбум буюу 29.8% нь банк болон санхүүгийн байгууллагын харилцах дансанд, 63.1 тэрбум буюу 19.8% нь хадгаламжид байршиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэлэн

мөнгө 7.2 хувиар, хадгаламж 46.7 хувиар, харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө 13.0 хувиар өссөн байна.

- Богино хугацаат хөрөнгө оруулалт

2019 оны II улирлын байдлаар 19 ББСБ-ын 2.4 тэрбум төгрөгийн цэвэр богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.2 хувийг бүрдүүлж байна.


Цэвэр богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн оны эхнээс 32.1% буюу 589.8 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 14.2% буюу 301.3 сая төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ.

Зураг 5 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/



Арилжааны үнэт цаасанд 96.1% буюу 2.3 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 3.9% буюу 94.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Зураг 6 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалтын 97.6 хувийг хувьцаагаарх, 2.2 хувийг Засгийн


газрын бондоорх үлдсэн 0.2 хувийг бусад хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

- Факторингийн тооцооны авлага, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, бусад хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 19.9 дахин нэмэгдсэн ба тусгай зөвшөөрөлтэй 24 ББСБ-аас 3 ББСБ-ын 4.6 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны авлага бүртгэгдсэн байна. Нийт 4.7 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны авлагын 96.9% буюу 4.5 тэрбум төгрөг нь хэвийн, 1.8% буюу 85.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн, 1.3% буюу 61.4 сая төгрөг нь чанаргүй авлага байгаа бөгөөд хугацаа хэтэрсэн болон чанаргүй авлагад 18.3% буюу 26.9 сая төгрөгийн факторингийн авлагын эрсдэлийн сан байгуулсан байна.

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө өмнөх оны мөн үеэс 474.6 сая төгрөгөөр өсөж 10.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 7 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



Бусад хөрөнгө оны эхнээс 22.8% буюу 21.7 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 15.8% буюу 16.0 тэрбум төгрөгөөр өсөж 117.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 7.6 хувийг бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 538 ББСБ-ын 68.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд 12.9 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 9 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/


Үзүүлэлт	2018- II	2019- II	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
<i>Үндсэн ба биет бус хөрөнгө</i>	52.4	68.1	15.8	29.4%
Барилга байгууламж	18.7	23.0	4.3	30.1%
Техник хэрэгсэл	18.4	25.8	7.4	23.1%
Тавилга эд хогшил	6.5	8.6	2.2	40.4%
Дуусаагүй барилга	4.5	5.0	0.5	33.3%
Биет бус хөрөнгө	4.3	5.7	1.4	11.0%
<i>Хуримтлагдсан элэгдэл</i>	9.7	12.9	3.2	31.7%
Барилга байгууламжийн	1.4	1.8	0.5	33.3%
Техник хэрэгслийн	6.1	8.3	2.2	33.1%
Тавилга эд хогшлын	2.3	2.9	0.6	36.4%
ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	42.6	55.2	12.5	29.4%

2.2 Зээл

2019 оны II улирлын байдлаар 478 ББСБ нь 1,096.7 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй, 360,345 зээлдэгчид зээлийн үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь нийт активын 66.8 хувийг бүрдүүлж байна.

2.2.1 Зээлийн зориулалт

Зураг 8 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/



2019 оны эхний хагас жилд 433 ББСБ нийт 861.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бол 442 ББСБ-ын 630.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 2019 оны II улирлын байдлаар 478 ББСБ-ын 1,096.7 тэрбум төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэлтэй гарчээ.

Олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл, хэрэглээний зээлд 563.8 тэрбум төгрөгийн зээл олгож, 408.6 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн, худалдааны салбарт 109.4 тэрбум төгрөгийн зээл олгож, 92.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгджээ.

Зураг 9 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/



2.2.2 Зээлийн багцын чанар


Хүснэгт 10 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн чанарын ангилал /тэрбум төгрөгөөр/	2018-II дүн	2019-II дүн	Өөрчлөлт
Хэвийн	653.8	956.5	46.3%
Хугацаа хэтэрсэн	34.4	42.9	24.4%
Чанаргүй:	80.2	97.4	21.5%
Хэвийн бус	17.1	23.3	36.3%
Эргэлзээтэй	17.8	22.5	26.2%
Муу	45.3	51.6	14.0%
(Зээлийн эрсдэлийн сан)	-57.8	-72.2	24.9%
Нийт зээл	768.3	1096.7	42.7%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	710.6	1024.5	44.2%
Нийт зээл (төгрөгийн)	743.0	1063.9	43.2%
Нийт зээл (валютын)	25.4	32.8	29.6%

Нийт зээлийн 956.5 тэрбум төгрөг буюу 87.2 хувийг хэвийн зээл, 42.9 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 97.4 тэрбум төгрөг буюу 8.9 хувийг


чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 51.5 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна.

Зураг 10 Зээлийн чанар



Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 болон 1.6 пунктээр буурсан бол хэвийн зээлийн хэмжээ 2.1 пунктээр өсчээ.

Зураг 11 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа



Нийт зээлийн эцсийн үлдэгдэлд эзлэх валютын зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 пунктээр буурсан дүнтэй гарчээ.

2.2.3 Зээлдэгчид

2019 оны II улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 492 ББСБ-ын 360,345 зээлдэгчид байна.

Хүснэгт 11 Ерөнхий статистик /харилцагчид/


Харилцагчдын мэдээлэл	Дүн	Хувь
Нийт харилцагчдын тоо	2,348,014	100.00%
Үүнээс: Эмэгтэй	1,169,219	49.80%
Хуулийн этгээд	2,381	0.10%
Зээлдэгчдийн тоо	360,345	100.00%
Хэвийн	330,461	91.71%
Хугацаа хэтэрсэн	15,483	4.30%
Чанаргүй:	14,401	4.00%
Хэвийн бус	6,346	1.76%
Эргэлзээтэй	3,743	1.04%
Муу	4,312	1.20%
Зээлдэгчдийн насжилт	358,632	100.00%
18-35 насны	207,479	57.85%
36-45 насны	92,793	25.87%
46-55 насны	42,832	11.94%
55-аас дээш	15,528	4.33%
Зээлдэгчдийн боловсрол	358,632	100.00%
-Дээд	226,155	63.06%
-Тусгай дунд	20,512	5.72%
-Бүрэн дунд	98,070	27.35%
-Дунд	9,733	2.71%
-Бага	4,162	1.16%

2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү

2019 оны II улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 492 ББСБ-аас 433 ББСБ нийт 861.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3% байна.

ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3%-тай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй бөгөөд банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.8 пунктээр өндөр гарсан байна.

Зураг 12 Зээлийн жигнэсэн дундаж хүү



3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт хөрөнгийн 24.7% буюу 377.9 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 75.3% буюу 1,155.2 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

2019 оны II улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 12 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/

Хөрөнгө	2018-II	2018-IV	2019-II	Өөрчлөлт			
				Оны эхнээс		Өмнөх оны мөн үеэс	
				Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
Өр төлбөр	255,219.3	307,453.8	377,956.6	70,502.8	22.9%	122,737.3	48.1%
Санхүүгийн эх үүсвэр	45,591.4	57,607.1	84,140.5	26,533.4	46.1%	38,549.2	84.6%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	133,729.1	151,009.6	167,315.2	16,305.6	10.8%	33,586.1	25.1%
Бусад эх үүсвэр	9,018.2	15,668.3	15,044.5	-623.7	-4.0%	6,026.4	66.8%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	16,687.2	23,477.8	33,805.6	10,327.8	44.0%	17,118.4	102.6%
Төслийн зээлийн санхүүжилт	16,560.8	17,848.8	17,809.6	-39.2	-0.2%	1,248.8	7.5%
Бусад өр төлбөр	33,632.6	41,842.2	59,841.2	17,999.0	43.0%	26,208.6	77.9%
Эздийн өмч	888,477.1	977,443.6	1,155,158.0	177,714.4	18.2%	266,680.9	30.0%
Хувьцаат капитал	707,799.1	740,759.0	892,235.6	151,476.6	20.4%	184,436.6	26.1%
Бусад өмч	8,412.4	10,598.7	31,253.9	20,655.2	194.9%	22,841.5	271.5%
Сангууд	438.1	532.7	776.5	243.8	45.8%	338.4	77.2%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	170,860.9	224,586.5	230,055.3	5,468.8	2.4%	59,194.4	34.6%
Хоёрдогч өглөг	966.6	966.6	836.6	-130.0	-13.4%	-130.0	-13.4%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	1,143,696.4	1,284,897.4	1,533,114.6	248,217.2	19.3%	389,418.2	34.0%

3.1 Өр төлбөр

ББСБ-ын өр төлбөрийн хэмжээ 2019 оны II улиралд өмнөх оны мөн үеэс 122.7 тэрбум төгрөгөөр буюу 48.1 хувиар, оны эхнээс 70.5 тэрбум төгрөгөөр буюу 22.9 хувиар өсөж нийт өр төлбөрийн хэмжээ 377.9 тэрбум төгрөг хүрсэн байна.


- Итгэлцлийн үйлчилгээний өглөг

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 31 ББСБ-ын 24 нь 84.1 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт пассивын 5.5 хувьтай тэнцэж байна.

Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн 84.1 тэрбум төгрөгийн 81.0% буюу 68.1 тэрбум төгрөгийг 23 ББСБ төгрөгөөр, 19.0% буюу 16.0

тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 11 ББСБ валютаар татан төвлөрүүлсэн байна.

Зураг 13 Итгэлцлийн үйлчилгээний өглөг



- Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2019 оны II улирлын байдлаар 84 ББСБ дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагын 167.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт хөрөнгийн 10.9 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 33.6 тэрбум төгрөгөөр буюу 25.1 хувиар, оны эхнээс 16.3 тэрбум төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн үзүүлэлт юм.

- Бусад эх үүсвэр

Бусад эх үүсвэр нийт пассивын 1.0% буюу 15.0 тэрбум төгрөгийг бүрдүүлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 66.8% буюу 6.0 тэрбум төгрөгөөр өссөн, оны эхнээс 4.0% буюу 623.7 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарчээ.


Бусад эх үүсвэрийн 20.7% буюу 3.1 тэрбум төгрөгийг мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг, 25.3% буюу 3.8 тэрбум төгрөгийг төлбөр тооцооны үйлчилгээний өглөг, 54.1% буюу 8.1 тэрбум төгрөгийг факторингийн үйлчилгээний өглөг бүрдүүлж байна.

- ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2019 оны II улирлын байдлаар 27 ББСБ 33.8 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргаж, хөрөнгө оруулалт татсан нь өмнөх оны мөн үеэс 2.0 дахин буюу 17.1 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 44% буюу 10.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

- Төслийн зээл санхүүжилт

Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/



2019 оны II улиралд 38 ББСБ 17.8 тэрбум төгрөгийн төслийн зээлтэй байгаа нь нийт хөрөнгийн 1.2 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 7.5% буюу 1.2 тэрбум төгрөгөөр өсжээ.

Богино хугацаат санхүүжилтээр 13 ББСБ 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байгаа бол урт хугацаат санхүүжилтээр 28 ББСБ 13.7 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна.


Төслийн зээлийн 9.8 тэрбум төгрөгийг гадаад байгууллагаас, 5.4 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас, 1.6 тэрбум төгрөгийг Засгийн газрын төслийн зээлийн эх үүсвэрээс, 1.0 тэрбум төгрөгийг бусад санхүүжилтээс бүрдүүлсэн байна.

- Бусад өр төлбөр

2019 оны II улирлын байдлаар 495 ББСБ 59.8 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт пассивын 3.9 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 77.9% буюу 26.2 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 43.0% буюу 18.0 тэрбум төгрөгөөр өссөн дүн байна.

3.2 Эздийн өмч

Зураг 15 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



Өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 30% буюу 266.7 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 18.2% буюу 177.7 тэрбум төгрөгөөр өсч 1.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь салбарын пассивын 75.3 хувийг бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгийн 77.2% буюу 892.2 тэрбум төгрөг нь хувь нийлүүлсэн хөрөнгө,

19.9% буюу 230.0 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг, 2.7% буюу 31.2 тэрбум төгрөгийг бусад өмч, 0.1% буюу 0.84 тэрбум төгрөгийг хоёрдогч өглөг, 0.1% буюу 0.78 тэрбум төгрөгийг сангууд бүрдүүлж байна.

2019 оны II улирлын байдлаар өөрийн хөрөнгийн голлох өөрчлөлтүүдийг харвал хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ оны эхнээс 20.4% буюу 151.5 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 26.1% буюу 184.4 тэрбум төгрөгөөр, хуримтлагдсан ашиг оны эхнээс 2.4% буюу 5.5 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 34.6% буюу 59.2 тэрбум төгрөгөөр өсжээ.

2019 оны II улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 66 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 38.6 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.0-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 345 ББСБ 57.0 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 128 ББСБ 4.4 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 13 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/

Интервал	ББСБ тоо	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
1.4 тэрбумаас доош	156	29.0%	71.4	8.0%
1.4-1.8 тэрбум хүртэл	255	47.4%	367.7	41.2%
1.9-2.4 тэрбум хүртэл	33	6.1%	68.5	7.7%
2.5-4.9 тэрбум хүртэл	73	13.6%	207.5	23.3%
5 тэрбум ба түүнээс дээш	21	3.9%	177.1	19.9%
НИЙТ	538	100.0%	892.2	100.0%

4. Орлого, үр дүнгийн тайлан

2019 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 158.3 тэрбум төгрөгийн орлоготой, 94.0 тэрбум төгрөгийн зарлагатай, 64.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.

Зураг 16 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



4.1 Орлого

2019 оны II улирлын байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.6% буюу 39.9 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ. Орлогын өсөлтийн 84.0 хувийг хүүгийн орлого бүрдүүлж байна.

Зураг 17 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/



• Хүүгийн орлого

Хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар буюу 33.7 тэрбум төгрөгөөр өсөж 132.9 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт орлогын 84.0 хувийг бүрдүүлж байна.

Хүүгийн орлогыг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн 125.2 тэрбум төгрөгийн орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн 5.3 тэрбум төгрөгийн орлого, үнэт цаасны хүүгийн 4.0 сая төгрөгийн орлого, 2.4 тэрбум төгрөгийн бусад хүүгийн орлого бүрдүүлж байна.

• Хүүгийн бус орлого

Хүүгийн бус орлого нь 2019 оны II улирлын байдлаар нийт орлогын 14.1% буюу 22.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 60.1% буюу 8.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт байна.

Зураг 18 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/



Хүүгийн бус орлогын өсөлтийн 98.7 хувийг санхүүгийн үйлчилгээний орлого бүрдүүлж байна.

Санхүүгийн үйлчилгээний орлогын өсөлтийн 91.2 хувийг үйлчилгээ хураамж шимтгэлийн орлого, 11.1 хувийг бусад орлогын өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулгын орлого 34.2% буюу буюу 231.3 сая төгрөгөөр, итгэлцлийн үйлчилгээний

орлого 67.2% буюу 1.6 сая төгрөгөөр буурсан байна.


Хүснэгт 14 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая төгрөгөөр/

Санхүүгийн үйлчилгээний орлого	2018-II	2019-II	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Итгэлцлийн үйлчилгээний орлого	2.3	0.8	(1.6)	-67.2%
Мөнгөн гуйвуулгын орлого	676.2	444.9	(231.3)	-34.2%
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	75.8	118.7	43.0	56.7%
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	5,627.2	13,184.1	7,556.9	134.3%
Бусад	2,623.3	3,541.5	918.2	35.0%
НИЙТ	9,004.9	17,290.0	8,285.1	124.6%

- Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогын 1.9 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 тэрбум төгрөг буюу 43.2 хувиар буурсан байна.

Зураг 19 Үндсэн бус үйл ажиллагааны орлого /сая төгрөгөөр/



4.2 Зарлага

Хүснэгт 15 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2017-II	2018-II	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Хүүгийн зардал	9.2	15.1	5.9	63.9%
Хүүгийн бус зардал	44.1	53.3	9.2	20.7%
Болзошгүй эрсдэлийн зардал	11.4	16.2	4.7	41.4%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1.5	1.5	(0.03)	-2.1%
Орлогын албан татварын зардал	5.7	7.9	2.3	40.5%
Нийт зарлага	72.0	94.0	22.0	1.6

- Хүүгийн зардал

Хүүгийн зардал нийт зардлын 16.1% буюу 15.1 тэрбум төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.9% буюу 5.9 тэрбумаар өссөн байна.

- Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардал нь 53.3 тэрбум төгрөг буюу нийт зардлын 56.7 хувийг бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.7% буюу 9.2 тэрбум төгрөгөөр өсжээ.

- Болзошгүй эрсдэлийн зардал

Нийт зардлын 17.2% буюу 16.2 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал бүрдүүлж байгаа ба энэ зардал нь өмнөх оны мөн үеэс 41.4% буюу 4.7 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарсан байна. Үүнд зээлийн эрсдэлийн зардал 4.1 тэрбум төгрөгөөр, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал 390.7 сая төгрөгөөр, авлагын эрсдэлийн зардал 275.5 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

- Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Нийт зардлын 1.6 хувийг буюу 1.5 тэрбум төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 2.1% буюу 31.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ.

4.3 Ашигт ажиллагаа


2019 оны II улиралд ББСБ-ууд 64.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 17.8 тэрбум төгрөгөөр буюу 38.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

2019 оны II улиралд 538 ББСБ-ын 438 нь буюу 81.4% нь 68.1 тэрбум төгрөгийн ашигтай, 89 нь буюу 16.5% нь 3.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, 11 нь буюу 2.0% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

5. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 538 ББСБ-ын 88.8% буюу 478 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 11.2% нь буюу 60 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 44 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 13 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 5 ба түүнээс дээш зохистой харьцаа алдагдсан 1 ББСБ байна.

Зураг 20 Зохистой харьцаа



5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 16 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	41	89.1%
1 зохистой харьцааг хангаагүй	1	2.2%
2 зохистой харьцааг хангаагүй	4	8.7%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
НИЙТ	46	100%

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 17 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	411	89.2%
1 зохистой харьцааг хангаагүй	40	8.7%
2 зохистой харьцааг хангаагүй	7	1.5%
3 зохистой харьцааг хангаагүй	1	0.2%
4 зохистой харьцааг хангаагүй	1	0.2%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	1	0.2%
НИЙТ	461	100%

5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.4-т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 18 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	26	83.9%
1 зохистой харьцааг хангаагүй	3	9.7%
2 зохистой харьцааг хангаагүй	2	6.5%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
НИЙТ	31	100%

Хүснэгт 19 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт


№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Журмын ...-г заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд			ЗХШҮ хангаагүй		ЗХШҮ хангасан		ЗХШҮ хангах шаардлагатай ББСБ-ын тоо
		3.4	3.3	3.2	ББСБ тоо	%	ББСБ тоо	%	
Хангах шаардлагатай ЗХШҮ-ийн тоо									
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	-	5	4	9	1.7%	529	98.3%	538
2	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	-	7	4	11	2.0%	527	98.0%	538
3	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	-	2	-	2	0.4%	536	99.6%	538
4	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	4	14	-	18	3.3%	520	96.7%	538
5	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	2	15	1	18	3.3%	520	96.7%	538
6	Өрийн бичгийн зохистой харьцаа	-	-	-	-	0.0%	538	100.0%	538
7	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+тилүү,- дутуу)	-	-	-	-	0.0%	492	100.0%	492
8	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	-	-	-	-	0.0%	492	100.0%	492
9	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	-	9	-	9	1.8%	483	98.2%	492
10	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	-	6	-	6	1.2%	486	98.8%	492
11	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	-	6	-	6	1.2%	486	98.8%	492
12	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	-	2	-	2	0.4%	490	99.6%	492
13	Үнэт цаасны эзэмшил, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	-	-	-	-	0.0%	492	100.0%	492
14	Нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	-	-	-	-	0.0%	492	100.0%	492
15	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	-	-	-	-	0.0%	31	100.0%	31
16	Компанийн өрийн бичиг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	-	-	-	-	0.0%	31	100.0%	31
17	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	-	-	-	-	0.0%	31	100.0%	31
18	Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	1	-	-	1	3.2%	30	96.8%	31
ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо		24	395	37					
ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо		7	66	9	538				
НИЙТ ББСБ-ИЙН ТОО		31	461	46					

* Байвал зохих зохистой харьцаа % Нийт ББСБ-ын тоонд эзлэх хувь

2019 оны жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 18 ББСБ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 18 ББСБ, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 11 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 9 ББСБ мөн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцааг 9 ББСБ тус тус хангаагүй буюу эдгээр таван зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хамгийн их алдагдсан байна.

хэтэрсэн зээл, 5.4 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Зээлийн эрсдэлийн санг хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 78.5 хувьд байгуулжээ.

Зураг 22 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



1.5 тэрбум төгрөгийн үндсэн (биет) ба биет бус хөрөнгөнд 427.9 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

- **Пассив**

Орон нутгийн 75 ББСБ-ын хөрөнгийн 90.9% буюу 33.9 тэрбум төгрөг нь эздийн өмч, 9.1% буюу 3.4 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. Орон нутгийн ББСБ-уудын нийт хөрөнгийн 82.2 хувийг буюу 30.7 тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлж байгаа ба энэ нь салбарын хувьцаат капиталын 3.4 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 22 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум.төг/	Дүн	Хувь
Өр төлбөр	3,387,838.4	9.1%
Санхүүгийн эх үүсвэр	1,276,967.4	3.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	593,200.0	1.6%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	100,000.0	0.3%
Төслийн зээлийн санхүүжилт	442,074.2	1.2%
Бусад өр төлбөр	975,596.8	2.6%
Эздийн өмч	33,939,732.1	90.9%
Хувьцаат капитал	30,692,485.7	82.2%
Бусад өмч	390,582.8	1.0%
Сангууд	561,643.0	1.5%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	2,295,020.6	6.1%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	37,327,570.6	100.0%


- **Орлого үр дүнгийн тайлан**

2019 оны II улиралд орон нутгийн ББСБ-ууд 4.1 тэрбум төгрөгийн орлоготой, 2.1 тэрбум төгрөгийн зарлагатай, 2.0 тэрбум

төгрөгийн цэвэр орлоготой ажиллаа. 66 ББСБ 2.2 тэрбум төгрөгийн ашигтай, 6 ББСБ 168.3 сая төгрөгийн алдагдалтай, 3 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Орлогын 90.3% буюу 3.7 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 5.5% буюу 228.2 сая төгрөгийг хүүгийн бус орлого, 4.2% буюу 173.2 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрдүүлж байна.

Зураг 23 Зарлагын бүтэц /ХОН-ын ББСБ-ууд/



6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Хүснэгт 23 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрөл	ББСБ-ын тоо
Зээл	27
Факторингийн үйлчилгээ	2
Төлбөрийн баталгаа гаргах	5
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	1
Гадаад валютын арилжаа	9
Итгэлцлийн үйлчилгээ	3
Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	5
НИЙТ	54

Тайлант улиралд 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай, 1085 хувьцаа эзэмшигчийн 27 ББСБ, 322 ажилтантайгаар 8 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 25,524 харилцагч, 22,743 зээлдэгчдэд хүрч үйл ажиллагаа

явуулж байгаа нь салбарын ББСБ-ын активын 13.7 хувийг эзэлж байна.

- **Актив**

Гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ-ын хөрөнгө 209.5 тэрбум төгрөг нь нийт хөрөнгийн 13.7 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 24 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	204,648,468.7	97.7%
Мөнгөн хөрөнгө	19,975,786.4	9.5%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	3,573.2	0.0%
Нийт зээл	169,775,358.2	81.0%
(Зээлийн эрсдэлийн сан)	-11,987,963.4	-5.7%
Зээл (цэврээр)	157,787,394.8	75.3%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	232,737.1	0.1%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	2,560,833.1	1.2%
Бусад хөрөнгө	24,088,144.1	11.5%
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	4,861,014.1	2.3%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	6,483,050.4	3.1%
(Хуримтлагдсан элэгдэл)	-1,622,036.3	-0.8%
Нийт хөрөнгийн дүн	209,509,482.8	100.0%

- **Пассив**

Пассивын 43.8% буюу 91.8 тэрбум төгрөгийг өр төлбөр, 56.2% буюу 117.7 тэрбум төгрөгийг эздийн өмч бүрдүүлж байна.

ББСБ-ын пассивын бүтэц нь эздийн өмч давамгайлсан бүтэцтэй байдаг бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд өр төлбөр болон эздийн өмчийн харьцаа ойролцоо дүнтэй байна. Өр төлбөрийн 56.4% нь дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 23.9% нь итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр байгаа бол эздийн өмчийн 71.8% нь хувьцаат капитал байна.

Дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн 72.0% буюу 37.3 тэрбум төгрөгийг богино хугацаат

зээл, 28.0% буюу 14.5 тэрбум төгрөгийг урт хугацаат зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 25 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив /мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
<i>Өр төлбөр</i>	91,841,191.8	43.8%
Санхүүгийн эх үүсвэр	21,951,522.7	10.5%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	51,797,446.4	24.7%
Бусад эх үүсвэр	760,402.4	0.4%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.0	0.0%
Төслийн зээлийн санхүүжилт	8,425,450.0	4.0%
Бусад өр төлбөр	8,906,370.3	4.3%
<i>Эздийн өмч</i>	117,668,291.1	56.2%
Хувьцаат капитал	84,442,041.8	40.3%
Бусад өмч	18,647,602.9	8.9%
Сангууд	4,098.1	0.0%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	14,379,548.2	6.9%
НИЙТ ПАССИВ	209,509,482.8	100.0%

Орлого үр дүнгийн тайлан

Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ 24.5 тэрбум төгрөгийн орлоготой, 16.0 тэрбум төгрөгийн зарлагатай, 8.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа ББСБ-ууд нь нийт ББСБ-уудын 8.6%, гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудын 29.9 хувийг бүрдүүлж байна.

65 хувьцаа эзэмшигчийн 46 ББСБ, 6 салбар, 124 ажилтантайгаар 36,035 харилцагчдад хүрч үйл ажиллагаа эрхэлж байна.

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 154 ББСБ байгаагаас дагнан эрхэлж байгаа 46 ББСБ-уудын 43 нь Улаанбаатар хотод, 3 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

- **Актив**

Хүснэгт 26 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	10,759,219.5	98.2%

Мөнгөн хөрөнгө	10,613,659.4	97.2%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,000.0	0.01%
Бусад хөрөнгө	144,560.1	1.0%
Эргэлтийн бус хөрөнгө	199,422.7	1.8%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	323,760.3	2.9%
(Хуримтлагдсан элэгдэл)	-124,337.5	-1.0%
НИЙТ ХӨРӨНГӨ	10,958,642.2	100.0%

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын нийт активын хэмжээ 10.96 тэрбум төгрөг байгаа нь салбарын активын 0.7% байна. Үйл ажиллагааны онцлогоос хамааран нийт активын 97.2% нь мөнгөн хөрөнгө, 0.01% нь богино хугацаат хөрөнгө оруулалт, 1.0% нь бусад хөрөнгө байгаа бөгөөд 1 ББСБ 1 сая төгрөгийн засгийн газрын арилжааны үнэт цаас худалдаж авсан байна.

- **Пассив**

Хүснэгт 27 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Өр төлбөр	125,211.2	1.1%
Хувьцаат капитал	10,004,862.4	91.3%
Бусад өмч	95,447.7	0.9%
Хуримтлагдсан ашиг	733,121.0	6.7%
Нийт пассив	10,958,642.2	100.00%

Нийт хөрөнгийн 91.3% буюу 10.0 тэрбум төгрөг нь хувьцаат капитал, 6.7% буюу 733.1 сая төгрөг нь хуримтлагдсан ашиг, 1.1% буюу 125.2 сая төгрөг нь өр төлбөр, 0.9% буюу 95.4 сая төгрөг нь бусад өмч байна.

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд 544.4 сая төгрөгийн орлоготой, 533.9 сая төгрөгийн зарлагатай, 10.5 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

25 ББСБ 85.8 сая төгрөгийн цэвэр орлоготой, 16 ББСБ 75.4 сая төгрөгийн алдагдалтай, 3 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хүснэгт 28 Орлогын бүтэц

НИЙТ ОРЛОГО	544,447.99	100.0%
Хүүгийн орлого	6,978.68	1.3%
Хүүгийн бус орлого	535,369.31	98.3%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,100.00	0.4%

Зарлагын бүтцийн хувьд 521.3 сая төгрөг нь хүүгийн бус зардал, 3.2 сая төгрөг нь үндсэн бус үйл ажиллагааны зардал, 9.5 сая төгрөг нь орлогын албан татварын зардал байна.

Хүүгийн бус зардлын бүтцийг авч үзвэл:

Зураг 24 Хүүгийн бус зардлын бүтэц



ДҮГНЭЛТ

2019 оны II улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 538 ББСБ-аас 96.3% буюу 518 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 20 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2019 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 7618 хувь нийлүүлэгчдийн 538 ББСБ, 235 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 2921 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 2,348,014 харилцагчдад хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 463 ББСБ, 164 салбар Улаанбаатар хотод, 75 ББСБ, 71 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2019 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1,533.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.0 хувиар буюу 389.4 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 19.3 хувиар буюу 248.2 тэрбум төгрөгөөр өсөж банкны салбарын нийт активын 4.4 хувьтай тэнцэж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 48 ББСБ нийт активын 50.1 хувийг, 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 379 ББСБ нийт активын 47.9 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 111 ББСБ нийт активын 2.0 хувийг эзэлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 1.1 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 6.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 956.5 тэрбум төгрөг буюу 87.2 хувийг хэвийн зээл, 42.9 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 97.4 тэрбум төгрөг буюу 8.9 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 51.5 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 492 ББСБ-аас 433 ББСБ нийт 861.3 тэрбум төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгосон нь банкны салбартай харьцуулахад 1.8 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 75.3% буюу 1.2 их наяд төгрөг нь өөрийн хөрөнгө, 24.7% буюу 377.9 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. 2019 оны II улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 66 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 38.6 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.0-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 345 ББСБ 57.0 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 128 ББСБ 4.4 хувийг бүрдүүлж байна.

2019 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 158.3 тэрбум төгрөгийн орлоготой, 94.0 тэрбум төгрөгийн зарлагатай, 64.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Үүнээс 438 нь буюу ББСБ-ын 81.4% нь 68.1 тэрбум төгрөгийн ашигтай, 89 нь буюу 16.5% нь 3.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, 11 нь буюу 2.0% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Нийт ББСБ-ын 88.8% буюу 478 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 60 ББСБ буюу 11.2% нь зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР